# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

## 2025 оны эхний хагас жил

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 1 | 1 | Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03 | 39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана. | 2025 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээнд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зардалд 20 сая төгрөг төсөвлөгдсөн | Хэрэгжсэн | | |
| 2 | 2 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01 | 19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийлэл ба, архи тамхины хор нөлөө үр дагаварын талаар сургалт нөлөөллийн ажлыг 2 удаа зохион явуулсан. Давхардсан тоогоор 104 хүүхэд хамрагдсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг орон нутгийн цахим хаягаар 3 удаа мэдээллийг хүргэж ажилласан. | Хэрэгжсэн | | |
| | 3 | | 19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн | Хамтарсан багийн гишүүдийг чадвахжуулах сургалтанд нэг удаа хамруулсан. 2025 оны хагас жилийн байдлаар хамтарсан багийн хурлыг 4 | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | удаа хийж, асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. | | | |
| | 4 | | 19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсөв батлагдаагүй. | Хэрэгжсэн | | |
| | 5 | | 19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахаар төлөвлөсөн. Одоогоор хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардал гараагүй байна | Хэрэгжсэн | | |
| | 6 | | 19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион | Түр хамгаалах байр байхгүй. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд тусгай өрөө, суурин | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: | компьютер, принтер, ширээ сандал, зэрэг тоног төхөөрөмжөөр хангагдан ажиллаж байна. | | | |
| | 7 | | 19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага байхгүй болно. | Х.Б | | |
| | 8 | | 19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг 2025 оны 06 дугаар сард Хамтарсан баг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтран зохион явуулсан. Гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр сэтгэл зүйч ажиллаж, явуулын үйлчилгээ үзүүлсэн. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 9 | Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29 | 15.2.4.. цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх; | Засаг даргын Тамгын газрын нийт төрийн албан хаагчдыг ERP системд холбож, албан хэрэгцээнд хэрэглэж хэвшүүлсэн байна. Мөн төрийн албан хаагчдын ирц бүртгэлийг ERP системээр хийж хэвшсэн. | Хэрэгжсэн | | |
| | 10 | | 15.2.7.. сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх. | 2025 оны сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг тухай бүрт зохион байгуулсан. | Хэрэгжсэн | | |
| | 11 | | 15.2.5.. хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх; | Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай, бусад эрх зүйн шийдвэрийг дагаж мөрдөн, төсвийн сахилга батыг хангуулан, өр, авлага үүсгэлгүй ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | | |
| 4 | 12 | Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг | 3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Сар бүр шаардлага хангасан 3 цэрний сорьц авч аймгийн лабораторт илгээсэн. Уушигны эмгэгтэй 1 иргэнийг аймгийн нэгдсэн эмнэлэгт илгээн онош тодруулсан ба улмаар УБ хотод цээжний МРА хийлгэж уушигны эмчийн үзлэгт хамруулж ажиллаж байна. Эрт илрүүлэх үзлэгийг аймгийн нэгдсэн эмнэлгийн эмчтэй хамтран зохион байгуулж 136 иргэнийг цээжний | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ | ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик ирүүлэх) | рентгэнд хамруулсанаас эрсдэлт бүлгийн 4 иргэнийг үзлэг шинжилгээнд хамруулж сүрьеэгийн эмчээс зөвлөгөө авсан. | | | |
| 5 | 13 | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ | 2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих. | 2025 оны 2 дугаар улирлын байдлаар ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээнд жирэмсний хяналтанд 13 эх хянагдаж байна. Давтан ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 13 эх хамрагдаж , шинээр гэр бүл болсон 1, ажилд шинээр бүртгүүлсэн 1 иргэнийг хамруулсан. | Хэрэгжсэн | | |
| 6 | 14 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай | 3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг | 2025 оны хагас жилийн байдлаар Гэр бүлийн боловсрол олгох сургалт 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 104 сурагч хамрагдсан байна. Доргонт багийн 1 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, сургалт өгсөн. Харилцан хүндэтгэе сарын аяны хүрээнд ЕБСургуулийн сурагчдад Гэр бүлийн хүчирхийлэл, архи тамхины хор нөлөө, үе тэнгийн дээрэлхэлт сэдвээр Дэвжээ тэмцээнийг | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах. | 30 сурагчийн дунд зохион явуулсан. ОНХСангаас 240.000 төгрөг зарцуулсан. ХГБХХГазрын сэтгэлзүйч  "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сургалтыг ТАХ, ААН иргэдэдэд зохион явуулж, 8 хүүхэд 26 насанд хүрэгч,  5 байгууллагын 42 төрийн албан хаагчид хамрагдсан. 2025 оны 6-р сарын 4, 5, 6-нд Хүүхэд, Гэр бүл хөгжил хамгааллын сэтгэлзүйч суманд ажиллаж, сэтгэлзүйн анхан шатны ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг 8 хүүхэд, 26 насанд хүрэгчдэд хүргэсэн бөгөөд, тусгай дугаарын 96-100-108 утсаар холбогдсон иргэдэд хүрч үйлчиллээ.  Мөн эрсдэлт нөхцөл дэх айл, архины хамааралтай иргэдтэй уулзан явуулын үйлчилгээ үзүүлсэн. | | | |
| 7 | 15 | Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19 Дугаар 2021 №8 БСШУСБХ | 1.12/. Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд  биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах. | Сумын хэмжээнд үндэсний спорт 4, багийн спорт 6, өвлийн спортын 1 нийт 11 тэмцээн уралдаан зохион байгуулж, 106 хүнийг хамруулан 6,876,000 төгрөг зарцуулсан байна. Түүхт 100 жилийн ойн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 50 сая төгрөгийн өртөг бүхий фитнесийн тоног төхөөржийг худалдан авч, фитнессийн тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдсэн. Фитнессийн багштай болж үйл ажиллагаа жигдэрсэн байна.ЕБС-ийн спорт талбайг хашаажуулах ажлыг ОНХС-ийн 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэж байна. "Хойд бүсийн лиг 2025" үндэсний шагайн харваан тэмцээнд Дашинчилэн сумын баг тамирчид амжилттай оролцож мөнгөн медаль хүртсэн. Тус тэмцээний шатахууны зардалд 500.000 төгрөгийг зарцуулсан. Нийт 10 тамирчин оролцсон. Үндэсний бөхийн спортоор | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 24, шагайн харваагаар 19, сурын харваагаар 35 хүн тус бүрийн төрөлд хичээллэж байна Монгол улсын ерөнхийлөгчийн санаачлагаар өрнөж буй "Эрүүл Монгол хүн" хөдөлгөөний хүрээнд “Идэвхтэй алхалтад-Цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээг 2025 оны 05 сарын 15-аас 06 сарын 20-ны хооронд зохион байгуулсан. Нийт 6 удаагийн тэмцээн уралдаан зохион байгуулсан байна. Аяны хүрээнд нийт давхардсан тоогоор 707 иргэнийг хамруулж, 2,191,500 төгрөг зарцуулсан байна. | | | |
| 8 | 16 | Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ | 1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох; | 2025 оны эхний хагас жилд тус суманд төлөвлөгөөний дагуу 14780 толгой малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулсан байна. Малын халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтыг сумын Засаг даргын 2025 оны А/41 дугаар захирамжаар төлөвлөх ажлыг зохион байгуулалтын арга хэмжээ авсан хэдий ч МЭЕГ-аас вакцинжуулалтын ажлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан. Тус сумын 3-р багт мал угаалгын суурин ванн бариулах 35 сая төгрөгний өртөг бүхий тендер зарлан гүйцэтгэгч шалгарч, гэрээг байгуулаад байна. 2025 онд мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэх 5 нэгжтэй сумын Засаг даргын 2025 оны А/22 дугаар захирамжаар гэрээ байгуулсан. 2024 онд 4 МЭҮН-тэй үйл ажиллагаа явуулж, 2025 онд 5 МЭҮН-тэй болсон. | Хэрэгжсэн | | |
| 9 | 17 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн | 1.4/. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, | 2025 оны ГЗБТ-д 29-н төлөвлөлтийн нэгж талбар батлагдсан. Үүнээс 12 нэгж талбарын захирамжийг гаргаж, мэдээллийн санд холбож ажилласан байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ | ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах; | | | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| 10 | 18 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн 4 байгууллагын хаягийг 1 стандартад оруулж, монгол бичиг, крилл үсэг, галигаар хослуулан бичүүлж, байршуулсан ба хувийн хэвшлийн 18 аж ахуйн нэгж байгууллагад гадна хаягийн байгууламжийг стандартын дагуу шинэчлэх талаар уриалга хүргэж ажилласан. | Хэрэгжсэн | | |
| 11 | 19 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ | 1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур | "Хөвөнтөн ой" ХХК засмал зам дагуух ойн зурвас байгуулах ажлын хүрээнд 3 га талбайг хашиж хамгаалсан. Энэ онд 5 төрлийн 520 мод нөхөн тариалалт хийсэн. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2021-10-04 Дугаар 2021_58 | амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах | | | | |
| | 20 | | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны хагас жилд 13 ААН, 103 өрх оролцож 1235 ширхэг мод бут суулгасан. | Хэрэгжсэн | | |
| | 21 | | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд | Зарлигийг хэрэгжүүлж, байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, төрийн болон төрийн бус байгууллага, нийт 11 байгууллагад уриалж ажилласан. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | | | | |
| 12 | 22 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай<br>2022-07-11<br>Дугаар 2022_159 | 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай. | Тус сумын Хүндэтгэлийн өргөө болон төрийн бүх байгууллагад Чингис хааны эш хөргийг залсан. | Хэрэгжсэн | | |
| | 23 | | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв ээ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | Тус сумын Хүндэтгэлийн өргөө болон төрийн бүх байгууллагад Чингис хааны эш хөргийг залсан. | Хэрэгжсэн | | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | | |
| 13 | 24 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2021-09-30<br>Дугаар 2021_03 | 3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн | “Тэр бум мод” хөтөлбөрийн хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 103 өрх 600ш мод, 13 ААН 115ш мод, “Хөвөнтөн ой” ХХК 520 ширхэг мод нөхөн тариалалт хийсэн байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | | | | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | |
| 14 | 25 | “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг батлах тухай 2021-06-01 Дугаар 2021_161 | 3. “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд сумдын Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай. | Тус суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Проектватт ХХК нь сумын төвийн засмал замын хойно дэд станцыг байгуулах, цахилгаан хангамж, шугам сүлжээний ажлыг татах ажлыг гүйцэтгэсэн. Тус ажлыг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ашиглатад хүлээн авсан. Ингэснээр засмал зам дагуур үйлчилгээний газрууд 380 шугамд холбогдсон. Мөн аймгийн төвийн 620 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж буй Эрүүл мэндийн төвийн барилгад дулаан хангамж болон эрчим хүчний дэд станц байгуулах ажил хийгдсэн. Нэгдсэн дулаан хангамжийн "Дулаан баян хайрхан" ХХК шинээр нөөц галлагааны зуух нэмж байрлуулан ажиллагаанд оруулаад байна. Шинээр 2 өрх дулааны шугамд холбогдсон. Хүн амын ундны усны хангамжийг сайжруулах ажлын хүрээнд шинээр худаг гаргах, ус цэвэршүүлэгч, ухаалаг худгийн систем суурилуулах ажлын тендер зарлагдаад байна. | Хэрэгжсэн | | |
| 15 | 26 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын | Төрийн албан хаагчийн сургалтын төлөвлөгөөнд Монгол бичгийн хичээлийг тусгаад байна. Мөн төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд Монгол бичгийн чадвараа ахиулах арга хэмжээг тусгасан. Албан байгууллага, аж ахуйн нэгжийн нэр хаягийг крилл болон үндэсний бичгээр бичих ажлыг зохион байгуулсан. Төрийн албан хаагчдын | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | Монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох, түвшинд тохирсон сургалтыг эхлүүлээд байна. | | | |
| 16 | 27 | Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай | 3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах | Сумын малын тоо толгойн албан татварын орлогоос хийгдэх 2025 оны ажлын жагсаалтад Малын үүлдэр угсааг сайжруулах, ялган тэмдэгжүүлэх ажилд 5.0 сая төгрөгийг тусгаад байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023-02-08<br>Дугаар 2023_63 | санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | | | | |
| 17 | 28 | Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай<br>2023-04-05<br>Дугаар 2023_119 | 2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 6 иргэний төлбөрийг төлүүлсэн | Хэрэгжсэн | | |
| 18 | 29 | Журам шинэчлэн батлах тухай<br>2023-07-19<br>Дугаар 2023_278 | 2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.(1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам) | Орон нутгийн хөгжлийн сангаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээний жагсаалтад 39 арга хэмжээ,малын тоо толгойн албан татвараар орсон орлогоор 2025 онд төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад 10 арга хэмжээ, байгаль хамгаалах нөхөн сэргээх орлогоор 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад 10 арга хэмжээг тус тус төлөвлөөд байна. төлөвлөгөөний дагуу ажлын хэсгүүдийг байгуулан ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| 19 | 30 | Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан | 3. 3.Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар | 2025 оны хагас жилийн байдлаар газрын хэмжээ өөрчлөх тухай 4 захирамж, эзэмших эрх шилжүүлэх 2 захирамж, газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгах 2 захирамж, гэр бүлийн хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2023-08-16 Дугаар 2023_294 | эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, сумын Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нарт үүрэг болгосугай. | гишүүнд шилжүүлэх 1 захирамж, нийт 12 захирамж, шийдвэрийг гаргаж ажилласан байна. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргаагүй болно | | | |
| 20 | 31 | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321 | 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | 2025 оны 2-р улирлын байдлаар “Осол гэмтлээс сэргийлье” сарын аяны хүрээнд 358 иргэдэд, “Хоол үйлдвэрлэлд шинэлэг хандлагыг нэвтрүүлэх нь” сарын аяны хүрээнд 583, “Архи тамхи шинэ үеийн сонголт биш” сарын аяны хүрээнд 256 иргэдэд, эрүүл мэндийг дэмжигч-Эрүүл аюулгүй ажлыэ байр сарын аяны хүрээнд 160 иргэн, Эрүүл мэнд-Идэвхитэй хөдөлгөөн" сарын аяны хүрээнд "Алхангаа ярилцья" явган аялал , 10000 алхая аян, Дашинчилэн хүүхдийн марафон -2025 аянд  нийт 707 иргэдийг хамруулсан. Мөн Дэлхийн тамхигүй өдөр, Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"ийг тэмдэглэн өнгөрүүлсэн. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "таны эрүүл мэндийн боловсролд" цахим зөвлөгөөг "Шүдний эрүүл ахуйг сахих" сэдвээр өгч ажилласан. | Хэрэгжсэн | | |
| 21 | 32 | “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай | 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр “Шүд угаах | "Эрүүл шүд” аяны хүрээнд “Шүд угаалтын аварга” шалгаруулах аймгийн тэмцээнд 4-7 дугаар ангийн 8 сурагчдыг хамруулсан. Нийт 144 хүүхэд хамрагдсанаас багаараа Дэд байр, | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023-08-30<br>Дугаар 2023_322 | цаг”-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | ганцаарчилсан төрөлд Тэргүүн байр тус тус эзэлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд “6 настнуудын үзлэг”, “24/3 шүдээ зөв угаая” уриан дор зарласан аяны хэргэжилтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс суманд эхлүүлсэн. “24/3 шүдээ зөв угаая” сэдэвт сургалтыг иргэд олон нийт, ЕБС-ийн сурагчдад зохион байгуулсан. ЕБС-ийн 1 дүгээр ангийн 50 сурагчид Нүүр амны урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсны үр дүнд 18 хүүхдийн амны хөндийг бүрэн эрүүлжүүлэн ажиллаж байна. | | | |
| 22 | 33 | Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай<br>2024-02-28<br>Дугаар 2024_82 | 2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг | Цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Орон нутгийн байгууллагуудын цалингийн зардлыг Сумын ИТХ-н 2024 оны III хуралдааны тогтоолоор 745,351.1 мян.төгрөгөөр батлуулсан. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.) | | | | |
| 23 | 34 | Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай<br>2024-02-28<br>Дугаар 2024_83 | 3.. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.) | 2024 онд журмын шаардлагыг хангасан 3 төрийн албан хаагчид урамшууллыг хуулийн дагуу олгосон. 2025 оны 2-р улирлын байдлаар 1 албан хаагчдад 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг хуулийн дагуу олгосон | Хэрэгжсэн | | |
| 24 | 35 | Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай<br>2024-04-03<br>Дугаар 2024_136 | 2.. Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. (“Улсын хэмжээнд 2024 онд иргэнд гэр бүлийн | Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолын дагуу сумын Засаг даргын 2025.05.16 өдрийн А/119 захирамжаар 13 иргэнд газар өмчлүүлсэн. Сумын Засаг даргын 2025.05.05 өдрийн А/99 захирамжаар худалдаа үйлчилгээний зориулалтаар 3 нэгж талбарын дуудлага худалдааны зарыг сумын цахим хаягт байршуулан, мэдээллийг хүргэн ажиллаж байна. Сумын Засаг даргын 2025.05.05-ны өдрийн “Төсөл сонгон шалгаруулалт явуулах тухай” захирамжаар малчдын хоршоонд мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар 24,987 га газрыг эзэмшүүлэх зарыг сумын цахим хаягт байршуулан, мэдээллийг хүргэн ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамтын хэрэгцээний зориулалтаар болон төрийн байгууллагад эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт, “Улсын тусгай хамгаалалттай газарт ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг 3 дугаар хавсралт) | | | | |
| 25 | 36 | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024-12-25 Дугаар 2024_238_1 | 2. 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж, 2025 онд орон тооны дээд хязгаарыг нэмэгдүүлэхгүй байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Орон нутгийн байгууллагуудын цалингийн зардлыг Сумын ИТХ-н 2024 оны III хуралдааны тогтоолоор 745,351.1 мян.төгрөгөөр батлуулсан. | Хэрэгжсэн | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 26 | 37 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим | Цахим тоон гарын үсгийн тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан сумын 16 ба түүнээс дээш насны иргэдэд цахим тоон гарын үсэг | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022-05-11<br>Дугаар 2022_28 | хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | олгох ажлыг хийж гүйцэтгэж байна. 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар ухаалаг утасны аппликэйшнд 380 иргэнд олгосон байна. Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойр, хүртээмжтэй хүргэх үүднээс иргэдийг орон нутгаас лавлагаа мэдээллээр хангадаг болсон. Үүнтэй холбогдуулан улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 430 иргэнийг лавлагаа мэдээллээр хангасан байна | | | |
| 27 | 38 | 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл<br>2022-08-24<br>Дугаар 2022_42 | ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар | "Хавдаргүй сум" болох зорилгын хүрээнд 6 дугаар сарын 20-ны байдлаар В, С вирусын шинжилгээнд 250 иргэнийг хамруулаад байна. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт 18-аас дээш насны 1911 иргэдийг хамруулахаас тайлант хугацаанд 336 иргэдийг хамруулж, хамрагдсан иргэдийн эзлэх хувь 17.5 хувь байна. Хүний папиллма вирусын вакцинд 11 насны 64 хүүхэд хамрагдахаас 52 охид, хөвгүүд | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | хамруулж, хамрагдалтын эзлэх хувь 81.2% байна. Дархлаажуулалтад 17-73 насны 75 иргэнийг хамруулаад байна. Хэвлийн хэт авиан шинжилгээнд нийт 120 иргэн, элэгний B, C вирус илрүүлэх шинжилгээнд 217 иргэн хамрагдсан. Элэгний B вирусын эсрэг вакцинд 60 иргэн хамрагдсан. Үүнээс 10 иргэн I тун, 50 иргэн II тунд хамрагдсан. Элэгний B, C, D вирусын халдвартай иргэдийн судалгааг шинэчлэн гаргаж ЭМГ-т хүргүүлсэн. Одоогоор элэгний B вирусын эмчилгээнд хамрагдаж байгаа 6 иргэн байна. | | | |
| 28 | 39 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар | Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн https://erp.e-mongolia.mn/ системийг ашиглан, цахим хэлбэрээр албан бичиг солилцох, шилжүүлэх ажлыг явуулж байна. Мөн төрийн албан хаагчдад өгсөн үүрэг даалгавар, үүрэг даалгаврын биелэлтийг https://erp.e-mongolia.mn/ системээр хянаж байна. Төрийн албан хаагчдын ирц бүртгэлийг 2025 оны 2 дугаар сараас тус системээр бүртгэж байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | | | | |
| 29 | 40 | 2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл 2023-03-22 Дугаар 2023_13 | IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл | 2025 оны 06 сарын 20-ний байдлаар газрын хэмжээ өөрчлөх тухай 4 захирамж, газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгах 2 захирамж, гэр бүлийн хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх 1 захирамж, газар эзэмших эрх шилжүүлэх 2 захирамж, Шинээр газар өмчлүүлэх 2 захирамж, Газар эзэмших дуудлага худалдаа 1, нийт 12 захирамж, шийдвэрийг гаргаж ажилласан байна. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргаагүй болно. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав. | | | | |
| 30 | 41 | Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэл 2024-12-30 Дугаар 2024_47 | 47.8.1.2. Нийслэлийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд бэлэн байдалд ажиллахыг Засгийн газрын гишүүд, нийслэлийн бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгов. | Сумын хэмжээнд шуурхай штабыг байгуулан, хариуцлагатай эргүүл жижүүрийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |

Хэрэгжилт тооцсон: ХЭЗДОАХМ Б.Батцэцэг